

Батлав:

Д.Даянбилгүүн  
Гүйцэтгэх захирал

65

“БиДиСЕК” ХК-ийн ТУЗ-ийн 2012 оны 03 дүгээр сарын 02 -ны өдрийн 03 тоот тогтоолоор батлав

## “БиДиСЕК” ХК-ИЙН ДОТООД ХЯНАЛТЫН ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь “БиДиСЕК” ХК-н (цаашид “компани” гэх) хувьцаа эзэмшигчид, оролцогч талуудын ашиг сонирхол, хууль ёсны эрх ашгийг хамгаалахын тулд компанийн үйл ажиллагаан дахь хяналтын тогтолцоог бүрдүүлэн хяналт тавих, илэрсэн зөрчил дутагдалыг арилгахад оршино.
- 1.2. Компанийн дотоод хяналтын үйл ажиллагааг ТУЗ-с 1 жилийн хугацаатай томилсон аудитын хороо хэрэгжүүлнэ.
- 1.3. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байх ба хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүдээс бүрдэнэ.
- 1.4. Энэхүү журамд нэмэлт өөрчлөлт оруулахыг компанийн ТУЗ-ийн хурлаар шийдвэрлэнэ.

### Хоёр. Аудитын хорооны ажлын чиглэл

- 2.1. Аудитын хороо нь дараах чиглэлээр ажиллаж дүгнэлт гарган ТУЗ-д танилцуулна.  
Үүнд:
  - 2.1.1. Гэрээ, хэлцэл, дүрэм, журмын хяналт
    - a. Бусадтай байгуулсан зээлийн болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх гэрээ зэрэг нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх
    - b. Их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй хэлцэл нь хуульд заасны дагуу байгуулагдаж буй эсэх
    - c. Компанийн дүрэм, журам нь хууль тогтоомжид нийцэж, хөрөнгө оруулагчдын ашиг сонирхолд нийцэж байгаа эсэх,
    - d. Компанийн дүрэм, дотоод журмын хэрэгжилтэнд хяналт тавих
    - e. Компанийн аливаа үйл ажиллагаа нь эрх барих байгууллагаас батласан хүчин төгөлдөр дүрэм, журмуудаар зохицуулагдаж буй эсэх
    - f. Үйл ажиллагааны гол үндэслэл болсон аливаа тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр байгаа эсэх
  - 2.1.2. Санхүүгийн тайлангийн хяналт
    - a. Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагааг тодорхой төлөвлөгөөнд үндэслэн гүйцэтгэж буй эсэх,
    - b. Компанийн эрсдлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих



- c. Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв хөтлөж байгаа эсэх
  - d. Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого нь хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн бүрэн бүтэн байдал, ашиглалтын үр ашигтай байдлыг хангаж чадаж буй эсэх
- 2.1.3. Мэдээ, мэдээллийг хууль журамд заасны дагуу хүргэж буй эсэх
- a. Тайлан мэдээ, мэдээллийг хууль журамд заасан цаг хугацаанд хувьцаа эзэмшигчдэд хүргэж буй эсэх
  - b. Хагас жилийн болон аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан хугацаанд гаргаж Зохицуулах хороо болон Хөрөнгийн биржид хүргэж буй эсэх
  - c. Холбогдох журмын дагуу тайлангийн хураангуйг хэвлэлд нийтлэж буй эсэх
  - d. Компани нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалыг гаргасан шийдвэрийн хамт 6 дугаар сарын 1-ний дотор, ээлжит бус хурлын материалыг хурал хуралдсанаас хойш 20 хоногийн дотор Зохицуулах хороонд хүргэж буй эсэх
- 2.1.4. Компанийн бусад үйл ажиллагаанд хяналт тавих

#### Гурав. Хяналт шалгалтын ажлын зохион байгуулалт

- 3.1. Компанийн хяналт шалгалтыг ТУЗ-өөс томилсон хянан шалгагч хийж гүйцэтгэнэ.
- 3.2. Хянан шалгагчийг томилох саналыг аудитын хорооноос ТУЗ-д танилцуулан шийдвэрлүүлнэ.
- 3.3. Хянан шалгагч нь шалгалтыг батлагдсан хуваарийн дагуу ээлжит, /сар улирал өдөр тутмын урсгал/ болон шаардлагатай тохиолдолд хийх гэнэтийн гэсэн хэлбэрээр компанийн аудитын хорооноос баталсан удирдамжийн хүрээнд 90 хоногт багтаан явуулна.
- 3.4. Хянан шалгагч нь ээлжит шалгалтыг хийхдээ шалгалтын зорилго, шалгалт хийх чиглэлийг шалгуулах этгээдэд албан ёсоор урьдчилан танилцуулна.
- 3.5. Хянан шалгагч нь зайлшгүй нэмэлт шалгалт явуулах шаардлагатай бол асуудлыг ТУЗ-ийн хуралд тавин хэлэлцүүлж батлуулна.
- 3.6. Хянан шалгагч нь шалгалтыг үндсэн баримтанд тулгуурлан явуулна.
- 3.7. Хянан шалгагч нь шалгаж буй асуудлын талаар урьдчилсан дүгнэлт гаргах, мэдээлэл хийх, шалгалтын материалыг өөр зорилгоор ашиглах, удирдамжид тусгагдаагүй асуудлаар шалгалт явуулахыг хориглоно.
- 3.8. Хянан шалгагч нь шалгалттай холбогдсон баримт бичиг, тайлан, цахим файлыг нууцлан хадгална.
- 3.9. Хянан шалгагч нь шалгалтын ажлын тайланг шалгалт дууссанаас хойш 3-хоногийн дотор аудитын хороонд танилцуулах ба аудитын хороо нь ТУЗ-ийн хуралд танилцуулна.
- 3.10. Их хэмжээний хэлцэл, сонирхолын зөрчил бүхий хэлцэл, эсхүл компанийн өдөр тутмын үйл ажиллагааны хүрээнд байнга гүйцэтгэдэггүй гэрээ, хэлцэл, ажиллагаатай холбоотой асуудлыг хянан шалгагчаар хянуулна.

Дөрөв. Хянан шалгагчийн эрх үүрэг

4.1. Хянан шалгагч нь дараах эрх эдэлнэ.

Үүнд:



- e. шалгалтад зайлшгүй шаардлагатай баримт материал, мэдээллийг зохих этгээдээс гаргуулах;
- f. шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, арилгах, төлбөр барагдуулах талаар холбогдох албан тушаалтанд хугацаатай үүргийн биелэлтийг хангуулах ;
- g. өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй болон гарсан зөрчилөөс хамааруулан зөрчил гаргасан ажилтанд байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн гэрээний дагуу арга хэмжээ авах саналыг ТУЗ-ийн хуралд гаргах;

4.2. Хянан шалгагч нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

- a. аудитын хорооны заасан чиглэл, удирдамжийн дагуу шалгалт явуулах;
- b. хууль тогтоомжийг чанд сахих, хөндлөнгийн нөлөөнд үл автах, шударга ёсыг дээдлэх, байгууллага албан тушаалтны нэр төрийг хүндэтгэх;
- c. шалгалт явуулсан тухай танилцуулга, акт бусад баримт бичгийг зохих журмын дагуу үйлдэж гарын үсгээр баталгаажуулах;
- d. шалгалтын материалыг зохих этгээдэд танилцуулж, гарын үсэг зуруулах, хэрэв зөвшөөрөөгүй буюу гарын үсэг зурахаас татгалзвал энэ тухай тайлбарыг бичгээр авах;
- e. танилцуулга, шалгалтын дүгнэлтийн үнэн зөвийг хариуцах;
- f. шалгалтын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээг эцэслэн хянах, үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах;
- g. шалгалттай холбогдолтой мэдээллийн нууцыг чанд хадгалах;
- h. шалгалтын дүнг аудитын хороонд тайлагнах.

Тав. Хүлээлгэх хариуцлага

- 5.1. Хянан шалгагч нь албадуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж алдаа дутагдал, зөрчил илэрсэн тохиолдолд акт тавих эрхгүй.
- 5.2. Хянан шалгагч нь зөрчил, алдаа дутагдлыг илрүүлсэн баримтыг аудитын хороонд танилцуулан, аудитын хороо нь ТУЗ-ийн хуралд тайлагнана. ТУЗ-өөс алдаа дутагдал, зөрчилд акт тавин 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.



---oOo---